

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 02/1956 дугаар албан бичгийн дөрөвдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн удирдлагатай байгуулсан “01/69 дугаартай хариуцлагын гэрээ”-ний хавсралт болох Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн “Байгууллагын гүйцэтгэлийн тайлан”-д хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнгийн талаар байгууллагын удирдлагыг бодит мэдээллээр хангах, хангалтгүй хэрэгжсэн зорилт, арга хэмжээний шалтгааныг тодорхойлох, гүйцэтгэлийн тайлан гаргах үйл ажиллагаанд цаашид анхаарах санал, зөвлөмж гарган Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийг дээд шатны байгууллагад тайлагнахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго чиглэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Аргачлал загвар батлах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/555 дугаар захирамжийн хоёрдугаар хавсалтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, үр дүнг тайлагнах болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ажиллав.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ын 2.1-д заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутам, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийнэ гэснийг баримтлан ажилласан.

Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ хийх үндэслэл нь: Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д “Байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Төлөвлөгөөний биелэлтийн хагас жилийн явцын тайланг 07 дугаар сарын 09-ний өдрийн дотор, жилийн эцсийн тайланг төсвийн шууд захирагч 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор үнэлэх бөгөөд үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллана” гэж журамд заасан.

Мөн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2.3 болон 2.4-д заасан аргачлалын дагуу “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжиж, үнэлэлт өгөх байдлаар хяналт-шинжилгээг хийсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь:

- ✓ Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ;
- ✓ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ;
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ гэсэн 4 хэсгээс бүрдсэн байна.

Гурав.Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүн

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” А/1128 дугаар захирамжаар НХААГ нь 4 нэгж, 40 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 1 стратегийн зорилго, 4 зорилтын хүрээнд нийт 44 арга хэмжээний хэрэгжилтийг гарган ирүүлсний дагуу хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.

Нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тайланг хугацаандаа батлуулж, тайлагнасан эсэхийг хүснэгт 1-ээр дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 1

№	Хэлтсийн нэр	Төлөвлөгөөг хугацаандаа батлуулсан эсэх	Хагас жилээр биелэлтийг хугацаандаа тайлагнасан эсэх	Бүтэн жилээр хугацаандаа тайлагнасан эсэх	Арга хэмжээний тоо
1	2	3	4	5	6
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Тийм	Тийм	Тийм	1 зорилго, 6 зорилт, 37 арга хэмжээ
2	Хууль, эрх зүйн хэлтэс	Тийм	Тийм	Тийм	1 зорилго, 4 зорилт, 25 арга хэмжээ
3	Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтэс	Тийм	Тийм	Тийм	1 зорилго, 4 зорилт, 28 арга хэмжээ
4	Мэдээллийн технологийн хэлтэс	Тийм	Тийм	Тийм	1 зорилго, 4 зорилт, 20 арга хэмжээ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ

Хүснэгт 2

№	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний ерөнхий ангилал	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Нийт
1	1 зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	7	19	13	5	44

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 бодлого, 4 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнасан.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дүнг хүснэгтээр:

№	Зорилго	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Үнэлгээ				Хувь
				90-100	80-89.9	70-79.9	0-69.9	
1	1	1	7	7				100
2		1	19	19				100
3		1	13	13			2	87
4		1	5	5				100
Нийт		4	44	42			2	97

Дөрөв.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн талаар

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ талаар 1 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллан тайлагнасан байна.

“2025-2028 онд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, “Хөтөлбөрийн хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлт”-ийг 2025 оны 02 дугаар 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар батлуулж, 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 9 зорилтын 21 арга хэмжээг төлөвлөн 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/35 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж, тайлагнасан. Хагас жилийн байдлаар хэрэгжилт 91 хувийн гүйцэтгэлтэй байна.



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 дугаар 13


А/26

2025-2028 онд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлт батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/1205 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалт, Газрын даргын 2022 оны А/135 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 11, 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 2025-2028 онд Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг нэгдгээр хавсралтаар, хөтөлбөрийн хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтийг хоорондоо хавсралтаар тус тус баталсугай
- Хөтөлбөрийн хэрэгжилт, хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтийг ханган тайлагнахад хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Ө.Оюунчимэг)-т үүрэг болгосугай
- Хөтөлбөр, хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтэд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (З.Отгонбат)-д зөвшөөрсүгэй
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар) - т үүрэг болгосугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д БАТЦЭЦЭГ



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 04


А/35

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар) - т үүрэг болгосугай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 7.1.1, 7.1.5 дахь заалт, Газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 11, 12 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө-г хавсралтаар баталсугай
- Төлөвлөгөөний хэрэгжилт, хүрэн үр дүн, шалгуур үзүүлэлтийг ханган ажиллахыг холбогдох албан хаагчдад нэгтгэн тайлагнахыг Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Отгонсүрэн)-д тус тус үүрэг болгосугай
- Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (З.Отгонбат) д зөвшөөрсүгэй
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар) - т үүрэг болгосугай

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д БАТЦЭЦЭГ

Тав.Дүгнэлт, зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ын 2.4-д “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлж дүгнэнэ” гэсний дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 44 арга хэмжээг дараах аргачлалаар дүгнэсэн.

$$\text{Төлөвлөгөөний хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100\%$$

Дээрх журмын 2.5-д заасны дагуу шилжүүлэн тооцоход Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн гүйцэтгэл (1 зорилгын 44 арга хэмжээний дундаж хэрэгжилт) 97% буюу “БҮРЭН ХАНГАЛТТАЙ” байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын дүнгээр 42 арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан “бүрэн хангалттай”, 2 арга хэмжээг сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь “хангалтгүй” ангилалд хамрагдаж байна.

Цаашид анхаарах дараах зөвлөмжийг Удирдлагын зөвлөлийн хурлын гишүүд болон холбогдох албан хаагчид хүргүүлж байна. Үүнд:

1.Жилийн эцэст төлөвлөсөн 2 арга хэмжээг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэн, зорилтот түвшинд хүргэх;

2.Бусад арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцэст өссөн дүнгээр зорилтот түвшинд хүргэн, нотлох баримтын хамт, тогтоосон хугацаанд тайлагнах.

ХЯНАСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.БАТЦЭЦЭГ

Ө.ОЮУНЧИМЭГ